

БАТЛАВ  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД

2025 оны ... сарын .... өдөр

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Улаанбаатар хот

2025 он 01 сарын 30

“Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай” хуульд Нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэрээс үл хамааран авто зогсоолын төрөл, тэдгээрт тавих нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтоохоор зохицуулсан.

Зам, тээврийн яамны гадна авто зогсоолыг байгууллагын болон нийтийн хэрэгцээний зориулалттай авто зогсоолын үйл ажиллагаанд шилжүүлж, авто зогсоолын менежментийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, авто зогсоолын нэгдсэн системд холбох, зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Тус Засгийн газрын 13-р байрны авто зогсоолын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангуулж, байгууллагын болон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн техник, технологийн дэвшилтэд (“RFID” Radio-frequency identification) болон (“ANPR” Automatic number-plate recognition) технологийн дагуу ажилладаг, төлбөр тооцооны хялбар шийдэлтэй авто зогсоолын үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдэд энэхүү урилгыг хүргүүлж байна.

Шалгарсан аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр тухайн талбайд төхөөрөмж байршуулж, системийн хөгжүүлэлт хийх бөгөөд борлуулалтын орлогоос зардлаа нөхөж ажиллана.

**Байршил:** Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны Засгийн газрын 13-р байрны гадаа авто зогсоол

Урилгын дагуу тухайн авто зогсоолыг сонирхогч хуулийн этгээд нь ажлын даалгаврын дагуу тоног төхөөрөмжийн үнийн санал, үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө болон холбогдох бичиг баримтыг үнэн зөв бүрдүүлэн, битүүмжилсэн байдлаар эх хувь, цахим хувийг бэлтгэн 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 15:00 цагаас өмнө “Зам, тээврийн яам”-ны А байранд /Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 13-р байр 1-р давхарт/ хүлээлгэн өгнө.

Тус өдрийн 15:30 минутад сонгон шалгаруулалтын оролцогчдод мэдээллийг нээлттэй зарлах болно.

**Сонирхсон хуулийн этгээд нь дараах баримт бичигт тусгагдсан материалуудыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:**

1. Аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээ, ерөнхий танилцуулга;
2. Сонгон шалгаруулалтад оролцох тухай албан бичиг;



3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу Түрээсийн нийт орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоосон “Нийтийн болон хувийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн зогсоолын жишиг төлбөр”-өөс багагүй байхаар тооцож үйл ажиллагаа явуулах аргачлал, хугацаа, орлого нөхөх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах;

4. Нийгэмд үзүүлэх нөлөө, ажлын байр нэмэгдүүлэх эсэх;

5. Санхүүгийн эх үүсвэр /төсөлд шаардагдах нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нотолсон дансны хуулга/;

6. Аж ахуйн нэгж байгууллагын чадавхыг харуулах мэдээлэл /татвар, нийгмийн даатгал гэх мэт/;

7. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх тоног, төхөөрөмж, дагалдах хэрэгслийн мэдээлэл;

8. Тоног төхөөрөмж нийлүүлэх үнийн санал, үйл ажиллагааны зардлын тооцоо,

9. Зогсоолын зай талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэмдэг тэмдэглэгээ, хаалт хашлагыг шинэчлэх төлөвлөгөө боловсруулах;

Тодруулга мэдээллийг дор дурдсан хаягаар хандан авч болно.

ТЗУГ-ын мэргэжилтэн А.Оюунболд [Oyunbold@mrttd.gov.mn](mailto:Oyunbold@mrttd.gov.mn), 99055640;

---o0o---

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН

А.ОЮУНБОЛД



БАТЛАВ.  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД



## ЗАСГИЙН ГАЗРЫН 13-Р БАЙРНЫ АВТО ЗОГСООЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Зам, тээврийн яамны гадна авто зогсоолыг байгууллагын болон нийтийн хэрэгцээний зориулалттай авто зогсоолын үйл ажиллагаанд шилжүүлж, авто зогсоолын менежментийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, авто зогсоолын нэгдсэн системд холбох, зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

#### 1.1. АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

"Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр"-ийн хүрээнд авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг хялбаршуулах, төлбөр тооцоог автоматжуулах систем хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Мөн Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах 2021-2024 оны төлөвлөгөөнд тус зорилтыг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Энэхүү зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр авто зогсоолын менежмент, үйл ажиллагааг хувийн хэвшилд хариуцуулж, авто зогсоолын нэгдсэн системд холбох ажлын хүрээнд шаардагдах хөрөнгө оруулалт, техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж зогсоолын үйл ажиллагааг эрхлэх ажлын даалгаврыг боловсруулав.

#### 1.2. ЗОРИЛГО

Зам, тээврийн яамны гадна авто зогсоолын үйл ажиллагааг сайжруулан хүртээмжийг нэмэгдүүлж, төлбөр тооцооны хялбар шийдэл нэвтрүүлэх.


### ХОЁР. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Зам, тээврийн яамны буюу Засгийн газрын 13-р байрны авто зогсоолын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангуулж, байгууллагын болон нийтийн хэрэгцээнд нийцүүлэн техник, технологийн дэвшилтэд ("RFID" Radio-frequency identification) болон ("ANPR" Automatic number-plate recognition) технологийн дагуу ажилладаг, төлбөр тооцооны хялбар шийдэлтэй авто зогсоолын үйл ажиллагаа явуулах. Шалгарсан аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр тухайн талбайд төхөөрөмж байршуулж, системийн хөгжүүлэлт хийх бөгөөд борлуулалтын орлогоос зардлаа нөхөж ажиллана.



## ГУРАВ. СИСТЕМИЙН ШААРДЛАГА

### 3.1. Авто зогсоолын системийн дугаар таних архитектур



#### 4. Гадна авто зогсоолын үйл ажиллагааны үндсэн нөхцөл:

4.1. Ажлын өдрүүдийн 07:00-22:00 цагийн хооронд төлбөртэй, харин амралтын өдөр болон бүх нийтийн баярын өдрүүдэд төлбөргүй,

-Төлбөрийг бэлэн мөнгөөр, банкны төлбөрийн картаар, гар утасны аппликэйшнээр, бусад банкны аппликэйшнээр иргэн өөрийн сонголтоор төлнө.

-Гэнтийн ослоос шалтгаалж байнгын 5 зогсоолын талбайг нөөцөд байлгана,  
- Авто зогсоолын нөөц нь нийт 108 ба ажилтан албан хаагчид 60-70 зогсоолыг тогтмол ашиглана.

-Бусад байгууллага болон харьяа байгууллагуудын дарга, удирдлагуудад зориулж 10 хүртэлх зогсоолын талбайг шаардлагатай үед нөөцөд авна.

-Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулж буй олон нийтийг хамарсан арга хэмжээний үед зогсоолыг бүрэн чөлөөлж болно.

4.2. Авто зогсоол удирдах системд хийгдэх үйлдлүүд:

1. Машины зогсоолын үүдэнд LED дэлгэц дээр сул зайг тоогоор харуулах боломжтой байх. орц/гарцын камерын ANPR өгөгдлийг ашиглан тооллогын мэдээллийг ашиглаж машины зогсоол дотор зай байгаа эсэхийг жолоочид шууд мэдэгддэг байх.





2. Автомашины номероор шүүж хайх, камерын бичглэгийг хадгалах боломжтой байх
3. Зогсоол нөөцлөх боломжтой байх
4. Яамны албан хаагчид болон харьяа байгууллагуудын автомашиныг таньж нэвтрүүлэх эсвэл төлбөрийн хөнгөлөлт тохируулах боломжтой байх

#### 4.4. Тоног төхөөрөмжийн шаардлага

Багц 1. Дугаар танигч болон RFID уншигч

1.1.1	Дугаар таних камер	ZKTeco LPRS4000 High-end License Plate Recognition Machine, with LPRC100 дүйцэхүйц	ш	2
1.1.2	Автомат хаалт	ZKTeco ProBG3030 Parking Barrier эсвэл ижил төрлийн	ш	2
1.1.3	RFID уншигч	ZKTeco U2000E UHF уншигч эсвэл ижил төрлийн	ш	2
1.1.4	RFID уншигч суулгах шон		ш	2
1.1.5	Бетон суурь		ш	3
1.1.6	Машин мэдрэгч модуль	ZKTeco LD01 Loop Detector	ш	2
1.1.7	Машин мэдрэгч кабел	Loop Cable for Parking Barrier Gate	м	60
1.1.8	Шилэн кабел	4 core	м	140
1.1.9	Шилэн кабел FDF		ш	2
1.1.10	Шилэн кабел jumper		ш	3
1.1.11	Шилэн кабел media converter		ш	1
1.1.12	Шилэн кабел залгаас		ш	2
<b>2</b>	<b>Авто зогсоол талбай тохижилт</b>			

Авто зогсоолын одоогийн зохион байгуулалт, зогсоол хуваарилалтыг шинэжилж болно. Зогсоолын цагаан зураас, тусгаарлах зурвас, хаалт, хашлага, замын хадаасыг шинэчилнэ. Авто зогсоолын үйл ажиллагааг мэдээллэх электрон самбар байршуулна.

#### Багц №2 Хяналтын камер

№	Төхөөрөмж	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>1</b>	<b>Хяналтын камер</b>			
1.1.1	Хяналтын дэлгэц	HP v194 19inch monitor	ш	1
1.1.2	8 порт сүлжээний свич	TP-Link 8-port 10/100Mbps Desktop Switch TL-SF1008D	ш	2
1.1.3	Хард диск	Skyhawk 1TB	ш	1



1.1.4	12в тэжээлийн блок	12v-1a adaptor	ш	1
1.1.5	4мп хяналтын гадна камер	Hikvision EXIR Bullet Camera H.265+ 4MP DS-2CD2T43G2-2I	ш	2
1.1.6	4 порт POE сүлжээний свич төхөөрөмж	Hikvision PoE 4-Port + 2-Port up Fast Ethernet Switch DS-3E0106P-E/M	ш	1
1.1.7	2мп хяналтын гадна камер	2MP Hikvision DS-2CD1023G0E-I	ш	3
1.1.8	2мп хяналтын дотор камер	2MP Hikvision DS-2CD2124G0-I	ш	1
1.1.9	Бичлиг хадгалах төхөөрөмж	Hikvision 7604q1 nvr	ш	1
1.1.10	4 порт POE сүлжээний свич төхөөрөмж	PLANET FSD-504HP 4-port 10/100Mbps 802.3at/af POE +1 port Fast	ш	1
1.1.11	Камерийн хөл	1293z	ш	1
1.1.12	Сүлжээний утас	UTP Cat6	м	300
1.1.13	Цахилгааны утас	провод 1x2.5	м	100
1.1.14	Хар хоолой		м	200

4.5. Зогсоолын үйл ажиллагааны менежмент хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн шаардлага

4.5.1. Авто зогсоолын үйл ажиллагаа эрхэлж байсан туршлага 2-оос дээш жил байх

4.5.2. Авто зогсоолын програм хангамжтай байх

4.5.3. Авто зогсоолын төлбөр тооцооны шийдэлтэй байх

4.5.4. Авто зогсоолын хэвийн ажиллагааг хангах ажилтан, багтай байх, дуудлагын утастай байх

4.6 Авто зогсоолын програм хангамжид тавих шаардлага

4.6.1. Зогсоолын байршил болон сул зогсоолын мэдээллийг газрын зурагт суурилсан платформуус харж болдог байх

4.6.2. Зогсоолын төлбөр тооцоог төлбөрийн олон сувгаар авах боломжтой байх ба тухайн системд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, гар утасны дугаар зэргээр бүртгэгдэх ба бүртгэлтэй хэрэглэгчид банкны данснаас зогсоолын төлбөрийг автоматаар суутган авах зэрэг төлбөрийн хурдан шуурхай шийдэлтэй байх.

---o0o---

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С.МЯНДАСМАА

